

МӨНГӨН ТЭМДЭГТ ХУУРАМЧ ЭСЭХИЙГ ТОГТООХ КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



С.Сэлэнгэ – Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний хэлтсийн бичиг судлалын шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч, Хууль сахиулахын их сургуулийн шинжилгээ зүйн магистрант

Товч агуулга: Уг илтгэлд мөнгөн тэмдэгт хуурамч мөн эсэхийг тогтоох шинжилгээний талаарх ойлголт, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн (цаашид ШШҮХ гэх)-ийн Криминалистикийн шинжилгээний хэлтэс (цаашид КШТ гэх)-т 2010-2014 онуудад хийсэн шинжилгээний явц, үр дүн болон статистик судалгаанд тулгуурлан энэ төрлийн шинжилгээний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, арга, аргачлалыг боловсронгуй болгох талаар тодорхой санал дэвшүүлэв.

Түлхүүр үгс: хуурамч мөнгөн тэмдэгт, валют, криминалистикийн шинжилгээ, шинжилгээний арга зүй, мэргэжилтэн, мөнгөн тэмдэгтийн нэгдсэн сан.

Олон улсын конвенци (Женев, 1928)-иос “мөнгөн тэмдэгт” гэдэгт “тухайн улсын нутаг дэвсгэр дээр албан ёсоор гүйлгээнд байгаа цаасан болон төмөр зоосыг ойлгоно” гэж тодорхойлжээ [1]. Тэгвэл “хуурамч мөнгө” буюу “хуурамч мөнгөн тэмдэгт” гэсэн ойлголт эрх зүйн хувьд нэгдсэн тодорхойлолтонд хүрээгүй байна. Монгол Улсын Эрүүгийн хууль /ЭХ-ийн 176 дугаар зүйл/-д, “үндэсний болон гадаадын мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж ашиг олох зорилгоор төлбөр, тооцооны хэрэгсэл болгон ашиглаж, борлуулсан зүйлс”-ийг ойлгохоор заасан байна [2].

Түүхийн эх сурвалжаас үзэхэд, XII-XIII зууны үед эртний Юань Улсад анхны цаасан дэвсгэртийг ялам модноос гаргаж авсан бөгөөд тухай үеийн хуулиар мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдсэн этгээдэд хатуу шийтгэл оноож байжээ. Тухайлбал, дундад зууны үеийн Европт мөнгө хуурамчаар үйлдсэн этгээдийг буцалсан усанд оруулах, хайлуулсан төмөр хоолоруу нь цутгах, эд хөрөнгө эзэмших бүх эрхийг нь хасах г.м. [3].

Өнөөгийн нөхцөлд мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг нь зөвхөн үндэсний аюулгүй байдал, банк санхүүгийн үйл ажиллагаанд төдийгүй улс, орны гадаад харилцаа, хамтын ажиллагаа, эдийн засгийн тогтвортой байдалд саад учруулахуйц олон улсын шинжтэй, улс үндэстэн дамнасан, зохион байгуулалттай хэлбэрт шилжээд байна. Олон улсын валют дотроос АНУ-ын доллар болон евро нь хуурамчаар үйлдэгдэх эрсдэл өндөртэй мөнгөн тэмдэгтэд тооцогдож байна. Монгол Улсын хувьд, өнгөрсөн зууны дунд үе хүртэл үндэсний валют болох төгрөгийг нууцлалгүйгээр үйлдвэрлэж байгаад, 1966 онд хуурамчаар үйлдэхээс сэргийлж, анх өлзий дүрс бүхий усан хээг мөнгөн тэмдэгтэд суулгаж өгсөн байна.

Өнгөрсөн зууны 90 оны эхээр мөнгөн тэмдэгтийг 100 хувийн хөвөн цаасаар бүтээж, усан хээ, металл утас, байнга давхцах дүрс, микро үсгэн шугам, ультра гэрэлд тодрох дүрс, гарт тэмтрэгдэх товгор хээ, сканер болон бүх төрлийн хувилагчаар олшруулсан тохиолдолд тодрох эсвэл хувилагдахгүй буюу гэрлийн ойлтоор тодрох дүрс зэрэг нууцлалтай болгосны дээр 2002 оноос эхлэн холограмм суулган үйлдвэрлэдэг болсон¹.

Монгол Улсад хуурамч мөнгөн тэмдэгтийг эргэлтэнд оруулсан тохиолдол өнгөрсөн зууны 90 оны эхээр анх бүртгэгдсэнээс хойш энэ тоо тогтмол өссөөр ирэв. Үүнийг ШШҮХ-ийн КШХ-т сүүлийн жилүүдэд хийсэн хуурамч мөнгөн тэмдэгт мөн эсэхийг тогтоох шинжилгээний статистик үзүүлэлт гэрчилж байна [Хүснэгт 1, 2, 3, 4-ийг хар].

Валютын	Төгрөг	Юань	Доллар	Рубль	Евро
---------	--------	------	--------	-------	------

¹www.mongolbank.mn

төрөл Он					
2008	4	-	1	-	-
2009	9	3	2	-	3
2010	11	2	2	-	-
2011	4	1	-	-	-
2012	6	3	1	-	-
2013	116	13	5	1	1
2014 оны 9 сарын байдлаар	242	15	10	4	-

Хүснэгт 1. 2008 оноос 2014 оны 9 дүгээр сарын хугацаанд ШШҮХ-д хийсэн хуурамч мөнгөн тэмдэг мөн эсэхийг тогтоох шинжилгээний тоон үзүүлэлтийг объектын төрлөөр харуулсан байдал

Дээрх үзүүлэлтийг валютын төрөл, дэвсгэртээр ялгаж үзвэл:

Монгол Улсын “Төгрөг”							
Валютын дэвсгэрт Он	50	100	500	1000	5000	10000	20000
2008		-	-	1	2	8	-
2009		-	-	-	3	82	180
2010		-	-	-	11	71	10
2011		-	-	-	5	7	4
2012		3	21	305	757	907	224
2013		-	-	-	25	20	604
2014 оны 9 сар	3	4	1	6	1021	1218	3768

АНУ-ын “Доллар”						
Он	1	5	10	20	50	100
2008	-	-	1	-	-	-
2009	-	-	-	-	-	3
2010	-	-	-	-	-	2
2011	-	-	-	-	-	-
2012	-	-	-	-	-	10
2013	-	-	-	-	-	264
2014 оны 9 дүгээр сар	5	3	3	2	1	61

БНХАУ-ын “Юань”			
Дэвсгэрт Он	20	50	100
2008	-	-	-
2009	-	-	30
2010	-	-	22
2011	-	-	2
2012	-	-	2
2013	-	-	67
2014 оны 9 дүгээр сар	1	3	37

ОХУ-ын “Рубль”		
Дэвсгэрт Он	500	1000
2013	-	10
2014 оны 9 дүгээр сар	4	-

Хүснэгт 2, 3, 4. Шинжилгээнд ирүүлсэн мөнгөн тэмдэгтийг валютын төрөл, дэвсгэртээр ялган харуулсан байдал /давхардсан тоогоор/

Он Илэрсэн газар	2008	2009	2010	2011	2012	2013	2014.9 дүгээр сар
Арилжааны банк, санхүүгийн байгууллага	1	5	3	-	3	107	238
Хүнсний болон барааны дэлгүүр, түц	-	1	2	1	-	6	11
Валют арилжааны төв болон цэг	-	-	1	-	2	4	2
Худалдааны төв, хүнс болон барааны зах	-	1	-	-	-	2	2
Шатахуун түгээх станц	-	1	4	-	-	-	4
УБТЗ-ын Олон улсын тасалбар түгээх цэг	-	-	-	-	-	2	-
Бусад газар	4	10	6	4	5	8	7

Хүснэгт 5. Хуурамч мөнгөн тэмдэгт илэрсэн газрыг тоон үзүүлэлтээр харуулсан байдал

Судалгаанаас харахад, хуурамч мөнгөн тэмдэгтийг ихэвчлэн арилжааны банк, санхүүгийн байгууллага болон олон нийтийн үйлчилгээний газраар дамжуулан хууль бусаар эргэлтэнд оруулж байна (Хүснэгт 5-ийг хар).

Олон улсын Конвенциас мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх аргыг хэд хэдэн байдлаар ялгасан байна. Тухайлбал,

1. Гар аргаар үйлдсэн мөнгөн тэмдэгтийг:


- гараар зурах;
- химийн урвалж бодис ашиглах;
- “хуваан таслах”;
- тоон үсэг, дугаарыг өөрчлөх;
- хэсэгчлэн өөрчлөх.

2. Техник хэрэгсэл ашиглан үйлдсэн мөнгөн тэмдэгтийг:

- тус тусад нь эх бэлтгэх;
- хэвлэлийн тоног төхөөрөмж ашиглах;
- дижитал төхөөрөмжийн тусламжтай;
- нийтлэг хэрэглээний техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах г.м.


Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний хэлсэст хийсэн мөнгөн тэмдэгт хуурамч мөн эсэхийг тогтоох шинжилгээний явц, үр дүнгээс харахад, төгрөгийг ердийн хэвлэлийн болон хувилах төхөөрөмж ашиглан олшруулахаас гадна нэмэлтээр усан тэмдэг, металл утас, холограмм зэрэг хамгаалалтын элементүүдийг дуурайлган хийх аргыг гол төлөв ашигласан байна. Эдгээр аргыг дараах байдлаар ялгаж болох юм. Тухайлбал:

1. Мөнгөн тэмдэгтийг бодит байдлаар хэвлэн олшруулах арга (Зураг 1,2,3).




Зураг 1, 2, 3

2. Мөнгөн тэмдэгтийг хэвлээд нэмэлтээр холограмм, хамгаалалтын металл утсыг мөнгөлөг саарал өнгийн будагч бодис болон зурагч хэрэгслээр тодруулах эсвэл усан хээг 2 цаасны дотор талд зурах, сери дугаарыг тодруулах буюу засварлах (Зураг 4, 5, 6, 7).



Зураг 4, 5, 6, 7

3. Хэвлэсэн мөнгөн тэмдэгтэд нэмэлтээр холограмм, хамгаалалтын металл утсыг мөнгөлөг саарал өнгийн лакаар будах, усан хээг 2 цаасны дотор талд дуурайлган зурах, сери дугаарыг тодруулах буюу засварлах аргаар үйлдсэн шинж тэмдэг (Зураг 8, 9, 10, 11).



Зураг 8, 9, 10, 11

4. Хэвлэмэл аргаар дууриалгасан мөнгөн тэмдэгтэд нэмэлтээр холограмм, хамгаалалтын утсыг мөнгөлөг саарал өнгийн цаас ашиглан орлуулан хийж, дээр нь дүрс, тоо сийлбэрлэх (2 цаасны голд бүхэлд нь мөнгөлөг цаас наах, гадна талд нь сийлбэрлэж наах зэрэг), усан хээг 2 цаасны дотор талд дуурайлган зурах (хэв ашиглах, цаасны дотор талд хэвлэх), сери дугаарыг тодруулах буюу засварлах (Зураг 12, 13, 14, 15) зэрэг аргуудыг ихэвчлэн ашигласан байна.



Зураг 12, 13, 14, 15. Холограммыг хуурамчаар үйлдсэн байдал

Хэдийгээр мөнгөн тэмдэгтийн үнэт цаасны нууцлалыг хуурамчаар үйлдсэн тохиолдол манай улсад бүртгэгдээгүй ч хуурамч доллар болон юантай жишиж үзвэл, мөнгөн тэмдэгтийн цаас болоод нууцлалын элементийг өндөр үзүүлэлт бүхий техник хэрэгсэл, хэвлэх төхөөрөмж ашиглан үйлдэх болсон байна (Зураг 16-20).

Дээрхи байдлаас харахад, энэ төрлийн шинжилгээний объект болон шийдвэрлэх асуултын цар хүрээг нэмэгдүүлэх, шинжилгээний онол, арга зүй, аргачлалыг боловсронгуй болгохын зэрэгцээ шинжээч, мэргэжилтэн нарын мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах цаг болсныг гэрчилж байна. Учир нь энэ төрлийн шинжилгээгээр гол төлөв шинжилж буй мөнгөн тэмдэгт хуурамч эсэх мөн хуурамч бол ямар аргаар үйлдсэн болох зэрэг хязгаарлагдмал хүрээнд асуултыг шийдвэрлэж байсан бол гэмт хэргийн үйлдлийн арга нарийссанаар, уг хүрээг өргөжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарав. Үүнтэй зэрэгцээд шүүхийн шинжилгээний төдийгүй энэ чиглэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэх, тэдгээрийг хэрэгцээтэй мэдээ, мэдээллээр хангах, мэдээлэл солилцох мөн мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, тогтоох чиглэлд тодорхой ажил хэрэгтэй байна. Тухайлбал, хуурамч мөнгөн тэмдэгтийн нэгдсэн сан бүрдүүлж ашигласнаар зөвхөн шинжилгээнд төдийгүй, гэмт хэрэгтэй тэмцэх практикт үр дүнгээ өгнө.



Зураг 16. Мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын утсыг дууриалгаж хийсэн байдал




Зураг 17. Сери дугаарыг засварласан шинж тэмдэг



Зураг 18. Усан хээний дүрсийг дууриалгаж хэвлэсэн шинж тэмдэг



Зураг 19. Цаасыг хавсаргаж наах аргаар үйлдсэн шинж тэмдэг



Зураг 20. Усан хээний дүрсийг хэв ашиглан цаасны гадна давхаргад будагч түрхэж тодруулсан шинж тэмдэг (БНХАУ-ын 100-ын дэвсгэрт)

Дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах саналыг дэвшүүлэв. Үүнд:

- мөнгөн тэмдэгт хуурамч эсэхийг тогтоох шинжилгээний онол, арга зүйг боловсронгуй болгох;
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний төвд “Мөнгөн тэмдэгтийн нэгдсэн сан” байгуулж, практикт ашиглах;
- мөнгөн тэмдэгт хуурамч эсэхийг тогтоох шинжилгээг иж бүрдэлтэй хийх арга, аргачлалыг боловсруулж, шинжилгээний практикт нэвтрүүлэх;
- энэ чиглэлд мэргэжилтэн сургаж, бэлтгэх зэрэг асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Мөнгөн тэмдэгт хуурамч мөн эсэхийг тогтоох шинжилгээнд хийсэн судалгааны үр дүнгээс харахад, уг төрлийн шинжилгээний эрэлт хэрэгцээ, шаардлага манай улсын төдийгүй олон улсын түвшинд жилээс жилд нэмэгдсээр байна. Иймд орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтанд тулгуурлан, шинжилгээний онол, арга зүй, аргачлалыг боловсронгуй болгох, уг салбарт шинэ техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нэвтрүүлж ашиглахаас гадна шинжилгээний объектын төрөл, зүйлийг нэмэгдүүлэх замаар мөнгөн тэмдэгтийн нэгдсэн сан бүрдүүлж ашиглах мөн энэ чиглэлд мэргэжилтэн сургаж бэлтгэх зэрэг ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Эдгээрийг шийдвэрлэснээр зөвхөн шинжилгээний чанар, үр дүн дээшлэхийн зэрэгцээ, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо бэхжих үндэс болно гэж судлаачдын зүгээс үзлээ.

Ном зүй

1. Монгол Улсын Эрүүгийн хууль. [Цахим сайт] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. 2016. – Нэвтрэх горим: <http://www.legalinfo.mn/law/details/50> – чөлөөт.
2. Углева Е.Ю. Способы подделки и защиты бумажных денежных знаков: история и современность // Юридическая наука и практика: Вестник Нижегородской академии МВД России. — 2011. — № 1(14). — С. 411-415.
3. ШШҮХ-ийн 2008-2013 оны 11-р сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд хийгдсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг тогтоох шинжилгээнд хийсэн дүн шинжилгээ.
4. 2013 оны 11-р сарын 06-ны өдрөөс 2014 оны 09-р сарын 01-ний өдөр хүртэлх хуурамч мөнгөн тэмдэгтэд хийсэн шинжилгээний дүгнэлтүүд.
5. Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан “Түйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах” тухай журам. УБ. 2006, 2013 он.
6. "2015/12 сарын гадаад худалдааны тойм". [Цахим сайт] 2015. – Нэвтрэх горим: www.mongolbank.mn. – чөлөөт.